

**“Нэр төр, гүтгэлэг” цувралын III хэсэг: Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах хэрэгцээ шаардлага**

**/Хууль зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах хэрэгцээг судалсан тухай тайлан, 2002 он. Глоб Интернэшнл ТББ/**

Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч нарт хууль зүйн зөвлөгөө өгөх, тэднийг сургалтанд хамруулах хэрэгцээ шаардлага хэр зэрэг байгааг тогтоох зорилгоор ярилцлага авах болон анкетын асуултын аргаар судалгаа хийсэн болно. Энэ судалгаа нь:

1. Хууль зүйн зөвлөгөө авах хэрэгцээ, шаардлага
2. Сургалт явуулах хэрэгцээ
3. Хариуцагчаар оролцсон сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүний өмгөөлөгч болон хэрэг, маргааныг шийдвэрлэсэн шүүгчдийн санаа бодол
4. Сургалт болон гарын авлагын хэрэгцээ, шаардлага гэсэн дөрвөн үндсэн асуудлыг тодорхойлоход чиглэгдсэн бөгөөд тайланг доорх гурван хэсэг тус бүрээр гаргав.

**1. Судалгааны цар хэмжээ, объектын талаар**

1.1. Судалгааны нэг дэх хэсгийг шийдвэр гаргах түвшингийн төлөөлөл бүхий хуульчид, хуулийн байгууллага, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон энэ салбарт идэвхтэй ажиллаж буй мэргэжлийн төрийн бус байгууллагуудын хүрээнд явуулсан болно.

1.2. Судалгаанд 25 хүн хамрагдсан бөгөөд ажил, мэргэжийн хувьд:

1. Хуульчид, хуулийн байгууллагын албан хаагч 16 хувь
2. Хэвлэл мэдээллийн байгууллагын захирал, эрхлэгч, сэтгүүлч 56 хувь
3. Төрийн бус байгууллагын тэргүүн, захирал 28 хувь

1.3. Судалгаанд хамрагдсан байгууллага, хүмүүсийн нэрс:

*1.3.1. Хуульчид, хуулийн байгууллага*

1. Цогням УДШ-ийн шүүгч
2. Ж.Сайнжаргал Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын дарга, хурандаа
3. Ж.Амарсанаа Үндсэн хуулийн цэцийн гишүүн, хуульчдын давтан сургалтын төвийн захирал
4. Б.Ундрах Нийслэлийн шүүхийн шүүгч

*1.3.2. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага*

1. М.Туяа "Монголын нэг өдөр" сонин
2. Эрхлэгч "Урт чихт" сонин
3. Эрхлэгч "Ноёд хатагтай" сонин
4. Д.Бадамгарав "Монгол төрх" сонин
5. Б.Ганчимэг "10 хоног" сонин
6. Л.Болормаа, орлогч эрхлэгч, "Снедер" сонин
7. Алтанцэцэг, Батбилэг сэтгүүлч, "Үнэн" сонин
8. Дуламсүрэн, сэтгүүлч, "Улаанбаатар таймс"

9. Д.Галсанжаргал, “МН-25 Телевиз”
10. Х.Слзийбаяр, ахлах редактор МҮТВ
11. Улаанбаатар радио 101.6
12. Б.Мөнхбал “Сансар” Катв
13. FM-102.5
14. Жанжинхvv редактор FM-107.5

### 3.2.3. Терийн бус байгууллага

1. Ц.Дашдондов МЧАСЭ-ийн Ерөнхийлөгч
2. Ц.Бат-Орших Монголын Сэтгvvлчдийн Холбоо,
3. Х.Наранжаргал ”Глоб интернейшнл” ТББ, тэргvvн
4. Д.Цэрэнжав ”Олон нийт ба хэвлэл мэдээлэл” ТББ
5. Р.Хадбаатар ”Монголын Сонины Холбоо”
6. О.Чинбаяр ”Монголын Чөлөөт Сонины Холбоо”
7. М.Мөнхмандах “Хэвлэлийн хvрээлэн”

## Нэг. Хууль зvйн зөвлөгөө авах хэрэгцээ шаардлага, зорилго

1.1 “Сэтгvvлчид болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгvvлчдийн байгууллагуудад хууль зvйн зөвлөгөө авах “байнгын” хэрэгцээ шаардлага бий эсэх ?”

1.1.1 Энэхvv асуултанд судалгаанд хамрагдсан хvмvvсийн:

- 1/ 16 хvн буюу 64 хувь “шаардлага бий”
- 2/ 6 хvн буюу 24 хувь “хааяа ийм шаардлага гардаг”
- 3/ 3 хvн буюу 12 хувь “байхгvй, мэдэхгvй” гэж хариулжээ.

1.1.2 Сургалт явуулах ”шаардлага бий” гэж хариулсан 16 хvнээс бусдыгаа телеелэхvйц дараах хvмvvсийн хариулсаныг сийрvvлье. Үvнд:

- *Ц.Дашдондов: МЧАСЭ-ийн Ерөнхийлөгч*

“Хууль эрх зvйн мэдлэг дутуу байна. Хэвлэл мэдээллийн салбарт хууль зvйн болоод хvний эрхийн vүднээс мэргэжлийн ёс зvйн ендер тvвшинд ажиллаж чадахгvй байгаагаас алдаа их гаргаж байгаа нь хэвлэлийн нэр хvндэд хор уршиг учруулж байна...”,

- *Х.Наранжаргал: ”Глоб интернейшнл “ ТББ*

“...Ийм шаардлага бий, учир нь хэвлэл нийтлэгчид еерийн орны хууль болон хэвлэл мэдээллийн эрх зvйн олон улсын хэм хэмжээг мэддэггvй...”,

- *Д.Цэрэнжав: “ОНМХ” ТББ*

“Ийм хэрэгцээ шаардлага байдаг боловч, хэвлэл мэдээллийнхэн vүнийгээ мэдэрдэггvй, мэддэггvй, ашигладаггvй ...”,

- *Ж.Амарсанаа: Үндсэн хуулийн цэцийн гишvvн, ХДСТ-ийн Захирал*

“...Хууль тогтоомжийг иргэн бvр тэр дундаа сэтгvvлчид мэдэж байх шаардлагатай...” гэж тус тус хариулжээ.

- *Р.Хадбаатар, Алтанцэцэг /Үнэн сонин/, Б.Ганчимэг /10 хоног сонин/,*

*Д.Галсанжаргал /МН-25 ТВ/, Ж.Сайнжаргал ЦЕГ-ын ТГ-ын дарга, Б.Цогням /УДШ-ийн шvvгч/, Ц.Бат-Орших, Д.Бадамгарав, М.Туяа нар шаардлагатай гэж хариулсан байна.*

1.2.3 “Ийм хэрэгцээ байдаг ч тогмол бус еереер хэлбэл байнгын хэрэгцээ байхгvй” гэж vзсэн буюу 1.1.1-г дурдсан хvмvvс дараахь байдлаар хариулжээ. Үvнд:

- *Б.Мөнхбал: “Сансар” Катв*

“ Байнгын хэрэгцээ байхгvй, гэхдээ шаардлага бол бий...”,

- О.Чинбаяр: МЧСХ

“Байнгын бус, хааяа ийм хэрэгцээ, шаардлага гардаг...”,  
Х.Сүлзийбаяр, Дуламсүрэн, М.Мөнхмандах нар “ийм хэрэгцээ байдаг ч тогтмол бус...” гэж тус тус хариулжээ.

1.3.Судалгаанд хамрагдаж “байхгүй”, “мэдэхгүй” гэж хариулсан оролцогчид дараахь байдлаар хариулжээ. Тухайлбал,

- Л.Болормаа: “Снедер” сонины орлогч эрхлэгч  
“байхгүй, бусад эх сурвалжаас ашиглах боломжтой...”

- Жанжинхүү: редактор FM-107.5  
“байнгын гэдгийг мэдэхгүй, хэрэгтэй байх...”

- Б.Ундрах: Нийслэлийн шүүх  
“ийм хэрэгцээ байдаг байх...” гэж тус тус хариулжээ.

1.2 “Энэхүү хэрэгцээ шаардлагыг хангах хууль зүйн товчоо, хуулийн зөвлөгөө өгөх байгууллага байгуулах шаардлагатай юу?”

1.2.1 Энэ асуултанд судалгаанд хамрагдсан хүмүүсийн

1. 11 хvн буюу 44 хувь “шаардлагатай”

2. 11 хvн буюу 44 хувь “шаардлагатай хэдий ч дагнасан байх нь ерөөсгөл”

3. 3 хvн буюу 12 хувь “хэрэггүй, шаардлага байхгүй” гэж тус тус хариулжээ.

1.2.2. Асуултанд “шаардлагатай” гэж хариулсан хүмүүс дараахь байдлаар хариулжээ.

Үүнд:

- Б.Цогням : Улсын Дээд Шүүхийн шүүгч

“Зах зээлийн хуулиар аливаа бизнес, вйлдвэрлэл, вйлчилгээг амжилттай хэрэгжүүлэх суурь хөрс нь “тулгын гурван чулуу” /эдийн засаг, технологи, хууль/ гэсэн онол юм.

Хэвлэлийн байгууллагын бүх вйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах шаардлагатай учраас эрх зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй алба байгуулах шаардлагатай”,

- Р.Хадбаатар: “эрх ашгаа хамгаалуулах үүднээс хэрэгтэй”,

- Б.Ганчимэг: “сэтгүүлчид сэтгүүл зүйн боловсрол эзэмшдэг учир энэ талын мэдлэг бага, тийм учраас эрхээ хамгаалуулах хууль зүйн зөвлөгөө өгөх байгууллага байгуулах шаардлагатай...”

Х.Наранжаргал, М.Туяа, О.Чинбаяр, Б.Мөнхбал, Ц.Бат-Орших, Д.Цэрэнжав зэрэг хүмүүс шаардлагатай гэж үзсэн байна.

1.2.3 “Хэдийгээр шаардлагатай ч дагнасан байх гэдэг нь ерөөсгөл” гэж үзсэн хүмүүс дараахь байдлаар хариулт өгчээ. Тухайлбал,

- Ж.Сайнжаргал: ЦЕГ-ын ТГ-ын дарга

“ хууль зүйн товчоог дагнасан байдлаар байгуулна гэдэг бол ерөөсгөл, учир нь өмгөөлөгчид өөр төрлийн вйл ажиллагаа явуулах хэрэгтэй”,

- Алтанцэцэг: “Үнэн” сонин

“Дагнасан байх албагүй, чадалтай өмгөөлөгчдийг хүмүүс таньдаг, тэр хүмүүсээр л вйлчлүүлнэ шүү дээ...”

- Ц.Дашдондов: “Хэрэгцээ нэг их байхгүй байх, өөрсдөө өөрийгөө хамгаалуулах хэрэгтэй...”

- Ж.Амарсанаа: “дагнасан хууль зүйн товчоо байх хэрэггүй болов уу, өмгөөлөгчдийг мэргэжил, ур чадварын хувьд өрсөлдүүлэх замаар хэрэглэгч сонгох ёстой”,

- Б.Ундрах:

“...тэдний вйл ажиллагааны нэг хэсэг л байна, иргэд чадалтай өмгөөлөгч рүү л явдаг...”

гэж хариулжээ.

1.2.4 “шаардлага байхгвй, хэрэггвй” гэж үзсэн хvmvvc дараахь байдлаар хариулжээ.

Тухайлбал,

- Х.Слзийбаяр : “ММ агентлаг”

“...хэрэггвй, учир нь ажил терлийн шугамаар янз бvрийн хуульчдаас шаардлагатай зvйлээ асуудаг, мөн хуулийн вэбээс хэрэгтэй зvйлээ хардаг ...”,

- М.Мөнхмандах : “Монголын Хэвлэлийн хүрээлэн”

“...хэрэгцээ байхгвй, сэтгvүлчид еерсдее эрхээ хэнээр хамгаалуулах вэ гэдгээ сонгох эрхтэй ...”,

- Л.Болормаа: “Снеедер” сонин

“...хэрэггвй ” гэж тус тус хариулжээ.

1.3 “Хэвлэл мэдээллийн салбараар дагнан мэргэшсэн хуульч, емгеелегч, шvүгчийг та мэдэх vv ? Мэдвэл нэрлэнэ vv ?, Тэд тоо болон мэдлэг ур чадварын хувьд хангалттай төвшинд бэлтгэгдсэн vv ?.

1.3.1. Энэ асуултыг дээр тавьсан асуултуудыг баталгаажуулах vүднээс асуусан бегеэд судалгаанд оролцсон хvmvvcийн:

1/ 76 хувь буюу 19 хvн “мэдэхгвй, боломжгвй”

2 / 24 хувь буюу 6 хvн “емгеелегч нэрлэж, еерсдийн санал бодлоо илэрхийлсэн” байна.

1.3.2 Асуултанд “мэдэхгвй, боломжгвй” гэж хариулсан хvmvvc дараахь байдлаар хариулжээ. Тухайлбал,

Ш Б.Цогням : Улсын Дээд Шvүхийн шvүгч

“...хуульчийг энэ чиглэлээр дагнан мэргэшvүлэх тогтолцоо байхгвйгээс дагнан мэргэшсэн хуульчийг нэрлэх боломжгвй”,

- Б.Ганчимэг : “ байхгвй байх...” гэж хариулсан бол бусад нь мэдэхгвй гэжээ.

1.3.3.Харин “емгеелегчдийг нэрлэж, еерсдийн санал бодлоо илэрхийлсэн” хvmvvc дараахь байдлаар хариулжээ. Тухайлбал,

- Ц.Дашдондов :

“С.Нарангэрэл, Б.Чимид гэж нэрлэн, хуулийнхан сэтгvүл зvйн ендер хөгжилтэй орнуудын жишигт нийцvүлэн, хангалттай мэдээлэл, мэдлэгт суралцах шаардлагатай байна...”,

- Х.Наранжаргал :

“...ийм хуульчийн тоо тун цөөн, хэвлэл мэдээллийн байгууллага ч, хуульчид ч vүнд онц ач холбогдол өгдөггвй, хуульч, сэтгvүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудын холбоо сул.”,

- Ц.Бат-Орших :

“...одоо л ойлгох төвшинд явж байна, цаашид мэргэшvүлэх хэрэгтэй гэж бодож байна.

Еереер хэлбэл, Сэтгvүлч-хуульч, хуульч гэвэл С.Нарангэрэл, Нямжав гэж нэрлэсэн” байна,

- Ж.Амарсанаа :

“ Хэдхэн хvн бий, нэрлэх шаардлага байхгвй биз. Хуульчид хангалттай төвшинд мэдлэгтэй байх ёстой...”

- О.Чинбаяр :

“ Ринчен, Амгалан, Батбаяр...”,

- Д.Бадамгарав :

“Л.Шинэн...” гэж тус тус хариулжээ.

## **Хоёр. Сургалт явуулах хэрэгцээ бий юу ?**

2.1. Энэ асуудлыг тодруулахын тулд доорх асуулт бvхий анкет 25 хvнд тарааж хариулт авсан юм. Үвнд:

“Сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллага, ТББ-дад Үндсэн хуулиар олгогдсон хууль зүйн баталгаа, хэвлэл мэдээллийн хууль, эрх зүй болон сэтгүүлчдийн эрх, үүрэг, хариуцлага, сэтгүүлчид хэрэг маргаанд холбогдсон үед хууль зүйн туслалцаа хэрхэн авах болон хэрэг маргаанд холбогдох, шүүхэд дуудагдахаас яаж урьдчилан сэргийлэх талаар сургалт явуулах шаардлага бий юу?”

2.1.1. Асуултыг нийт судалгаанд оролцогчдын дунд тавьсан бөгөөд судалгаанд оролцогчдын

1. 96 хувь буюу 24 хvн “шаардлагатай”

2. 4 хувь буюу 1 хvн “шаардлага байхгvй” гэж vзсэн байна.

2.1.2 Шаардлагатай гэж vзсэн хvмvvc асуултанд дараахь байдлаар хариулт өгчээ.

- Б.Цогням: “УДШ-ийн шvүгч”

“Сэтгүүлчийн эрх зүйн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалт явуулах, мэргэшүүлэх, дагнах чиглэл баримтлах нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдтэй холбоотой аливаа хэрэг, маргааныг vнэн зөв, шударга шийдвэрлэх ач холбогдолтой...”

- Ж.Амарсанаа: “Үндсэн хуулийн цэцийн гишvүн, Хуульчдыг давтан сургалтын төвийн захирал”

“...Шаардлага бий, хуулиа, эрхээ мэдсэний vндсэн дээр амжилттай ажиллах бөгөөд нийгмийн vнэлэмж төдий чинээ нэмэгдэж, тэдний vүрэг, статус дээшлэнэ.”

- Д.Цэрэнжав: “Монголын ОНМХ-ийн тойм” сэтгүүл

“...шаардлага байдаг, гэхдээ хууль зүйн орчин бүрдүүлж байж л сургалт явуулах шаардлагатай. Сөрөөр хэлбэл, заах зvйлээ тодорхойлж байж л сургалт явуулах хэрэгтэй”.

- Р.Хадбаатар : “...зайлшгvй чухал”,

- М.Туяа: “Монголын нэг өдөр” “шаардлагатай, хуулийн мэдлэггvйгээс болж хохирдог...”

- Х.Наранжаргал: Глоб интернейшнл ТББ “...шаардлагатай.

Нэг.Хэвлэлийн хууль эрт батлагдаагvйгээс сэтгүүлч, хэвлэн нийтлэгчдийн дунд хэвлэл мэдээлэл хязгааргvй эрхтэй, чөлөөтэй хөгжих ёстой гэсэн төсөөгдөл байдаг.

Хоёр.Мэдээллийн эх сурвалжыг нотлох аргуудын талаар мэдлэг сул,

Гурав.Үүргээс гадна хариуцлагаа ухамсарладаггvй...”

- Ц.Бат-Орших: МСЭХ

“...шаардлагатай, эрхийн мэдлэг бага байна, сэтгүүлчдийг бэлтгэх программ боловсруулах хэрэгтэй...”

- Ц.Дашдондов: МЧАСЭ “шаардлагатай, гэхдээ сургалт дутаад

байгаа гэж ойлгож болохгvй, хангалттай сургалт явагдсан гэдгийг хэлэх хэрэгтэй...”

- Б.Ганчимэг: “10 хоног” сонин

“ хэрэгтэй бөгөөд эхний шатанд нь сонин өөрсдийн хvмvүсийг бэлтгэх хэрэгтэй...” гэж тус тус хариулжээ.

### **Гурав. Хариуцагчаар оролцсон сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл түүний өмгөөлөгчид болон хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүгчдийн санаа бодлыг судалсан тухай**

3.1 Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд хууль зүйн зөвлөлгөө өгөх, сургалт явуулах шаардлагын судалгааг энэ талын хэрэг, маргаанд оролцоогvй хvмvүсээс авсан тайланг өмнөх 2 хэсэг (нэг, хоёр)-т тайлагнасан бол энэ гуравдахь хэсэгт “оролцсон хvмvүсээс” авсан судалгааны тайланг тусгав. Тухайлбал судалгааны энэ хэсэгт сvүлийн 2 жилийн хугацаанд бусдын нэр төр, алдар хvндийг гутаасан тухайн хэрэг, маргааны

хариуцагч, түүний өмгөөлөгчөөр оролцсон болон хэрэг шийдвэрлэсэн шүүгч бүгд 18 хүнийг хамарч явуулсан бөгөөд тэдгээр хүмүүсийн 28 хувь нь шүүгч, 28 хувь нь өмгөөлөгч, 44.4 хувь нь хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчид байв. Үүнд:

### 3.1.1 Хуулийн байгууллага, хуульчид

1. Б.Цогням УДШ-ийн шүүгч
2. Б.Ундрах Нийслэлийн шүүхийн шүүгч
3. Туяа СБД Шүүх, шүүгч
4. Б.Нямсүрэн СБД Шүүх, шүүгч
5. Б.Сарантуяа ЧДШүүх, шүүгч
6. Энхбаяр Өмгөөлөгч
7. Ё.Энхбулган Өмгөөлөгч
8. Э.Болорчулуун "Сувд" ХЗТ, захирал
9. С.Төгс "Төгс" ХЗТ
10. Л.Шинэн Өмгөөлөгч

### 3.1.2 Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид

- 1.Б.Ерэнтэй "Зууны мэдээ", орлогч эрхлэгч
- 2.Б.Хулан "Хүмүүсийн амьдрал"
- 3.С.Баярменх "Сэрүүлэг" сонин, эрхлэгч
- 4.Д.Заяабат "Өнөөдөр" сонин, албаны дарга
5. Б.Одгэрэл "Шар сонин" эрхлэгч
- 6.О.Мөнх-Эрдэнэ "Хүмүүс" сонин, эрхлэгч
- 7.Ханддолгор "Үг" сонин, эрхлэгч
- 8.М.Туяа "Монголын Нэг өдөр"

### 3.2 . Хууль зүйн зөвлөгөө шаардлагатай эсэх тухайг :

"Сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл сэтгүүлчдийн байгууллагуудад хууль зүйн зөвлөгөө авах байнгын хэрэгцээ шаардлага бий эсэх, дээрх хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн хуулийн зөвлөгөө өгөх байгууллага, хууль зүйн товчоо байгуулах шаардлагатай эсэх" гэсэн асуултаар авсан юм.

3.2.1 Энэ асуултанд судалгаанд хамрагдсан 18 хүн 100 хувь "хууль зүйн зөвлөгөө өгөх байнгын хэрэгцээ бий" үзжээ. Үүнийгээ тэдний зарим нь дараахь байдлаар тайлбарлаж байна. Үүнд:

- *Туяа: СБД шүүхийн шүүгч*

"...шаардлагатай. Яагаад гэвэл, хэвлэл мэдээллийн ажилтанууд, ялангуяа сэтгүүлч, сурвалжлагч нар нь хууль эрх зүйн мэдлэг дутмагаас мэдээллийн эх сурвалжийг шалгаж тогтоохгүйгээр бусдын нэр төр, алдар хүндэд нөлөөлсөн нийтлэл, мэдээлэл бичдэг. Үүнээсээ болж багагүй хохирол төлөх болдог..."

- *Б.Ерэнтэй: "Зууны мэдээ" сонины орлогч эрхлэгч*

"... энэ бол шаардлагатай. Одоо сэтгүүлчдийн байгууллага эрх нь хөндөгдсөн, дуртай хүний гомдлоо шалгагдаж байгаа сэтгүүлчдээ өмгөөлөх, хууль зүйн талаас нь үнэн зөвийг олох тал дээр туслан ажиллаж чаддаггүй. Өөрсөд нь хуулийн мэдлэг боловсрол дутагдаж байдаг учраас уг асуудалд орооцолдохоос зайлсхийдэг..."

- *Б.Хулан: "Хүмүүсийн амьдрал", эрхлэгч*

"...Монголд хөлөө олохгүй, дутагдаж байгаа "асуудал". Хэвлэл мэдээлэл аль хэдийн

нийгмийн өмнө байр сууриа эзэлчихээд байхад хууль эрх зүйн орчин нь бүрдээгвй байгаа нь харамсалтай... сонин хэвлэлийн нэр хүндийг өндөр авч явахад хуулийн талын зөвлөгөө өгдөг, алдахад нь түвшчихдэг хуулийн байгууллага хэрэгтэй...”

- *С.Баярмөнх* : “Сэрүүлэг” сонин эрхлэгч

“ Ийм хууль зүйн товчоо байх шаардлагатай. Учир нь олон сэтгүүлчид нэр төр гутаасан хэргээр буруутаж, шүүхээс их хэмжээний мөнгөний торгууль оногдуулж байна. Сэтгүүлчид хууль эрх зүйн мэдлэггүйгээс алдах явдал амьдралд их гарч байна...”

-*Д.Заяабат*: “Өнөөдөр” сонин, албаны дарга

“...Монголын сэтгүүлчдэд ус, агаар мэт хэрэгтэй зүйлийн нэг яах аргагүй хууль эрх зүйн мэдлэг. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжиж буй өнөө үед хуулийн зохих мэдлэггүйгээр ажиллахад хэцүү. Иймээс хууль, эрх зүйн туслалцаа авах байнгын байгууллага байх нь зүйтэй...”

- *Б.Одгэрэл*: “Шар сонин” эрхлэгч

“...хэвлэл мэдээллийн байгууллагуудад нийтэд нь үйлчилдэг мэргэжсэн 1-2 хуульч байж болох юм. /байнгын/”,

-*О.Мөнх-Эрдэнэ*: “Хүмүүс” сонин эрхлэгч

“... хуулийн зөвлөгөө авах байнгын хэрэгцээ бий, харин хууль зүйн товчоо байгуулах шаардлагатай эсэхэд хариулт өгч чадахгүй нь. Учир нь хувь хүн, байгууллага хоёрын алинд нь итгэх вэ, энэ хоёрын хэн нь үнэнч, хариуцлагатай байж чадах вэ ?...”

- *Б.Сарантуяа*: ЧДШүүхийн шүүгч

“...сэтгүүлчид эрхийн мэдлэг дутмагаас болж эд материалын хохиролд ертөх явдал цөөнгүй гарч байна. Энэ үүднээс шаардлагатай үед нь хууль зүйн зөвлөгөө өгөх товчоо байгуулж болно. Ингэснээр тэд хууль зөрчих явдал багасч болно...”

- *Л.Шинэн*: Өмгөөлөгч

“... дээрхи байгууллагуудад хууль зүйн зөвлөгөө авах байнгын хэрэгцээ байдаг, ийм төрлийн хууль зүйн товчоо байгуулахад буруудах зүйлгүй. Гэхдээ, уг товчоо нь ганц ийм төрлийн үйл ажиллагаа явуулна гэвэл оршин тогтнох боломжгүй. Ер нь иймэрхүү төрлийн өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байхад сэтгүүлчид болон сонин байгууллагууд нь эрх зүйн мэдлэг дутмаг байдаг ба энэ байдлаасаа болж буруудах явдал их гардаг...” гэж тус тус хариулжээ.

3.3. “Хэвлэл мэдээллийн салбараар дагнан мэргэжсэн хуульч, өмгөөлөгч, шүүгчийг та мэдэх эсэх, мэдвэл нэрлэнэ үү ? . Тэд тооны хувьд болон мэдлэг ур чадварын хувьд хангалттай түвшинд бэлтгэгдсэн гэж та үзэж байна уу ?”

3.3.1 Энэ асуултанд судалгаанд хамрагдсан хүмүүсийн,

1. 50 хувь буюу 9 хүн хариулт өгч, өөрийн санал бодлоо илэрхийлжээ.

2. 50 хувь буюу 9 хүн нь энэ салбараар дагнан мэргэжсэн хуульч, өмгөөлөгч, шүүгчийг “мэдэхгүй” гэж хариулжээ.

3.3.2. Асуултанд өмгөөлөгч бий гэж, өөрийн санал бодлоо илэрхийлсэн хүмүүс дараахь байдлаар хариулжээ. Тухайлбал,

- *Туяа*: СБД-ийн шүүхийн шүүгч

“...хуульч Ичинноров, өмгөөлөгч Энхдалай нараас өөр мэдэх хүн алга. Тооны хувьд хангалтгүй, мэдлэг, ур чадварын хувьд мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдээгүй, зөвхөн өөрсдийн сонирхолын хэмжээнд ажилладаг болов уу ?...”

- *О.Мөнх-Эрдэнэ*: "Хүмүүс" сонин, эрхлэгч  
"...емгээгч тодорхой хэдэн хүн бий, бусдыг нь мэдэхгүй, ур чадвар боломжийн...",  
- *Б.Хулан*: "Хүмүүсийн амьдрал" сонины эрхлэгч  
"...емгээгч Л.Шинэн...",  
- *Б.Одгэрэл*: "Шар сонин", эрхлэгч  
"...емгээгч Л.Шинэн, Н.Батбаяр нар сүүлийн 2-3 жилийн хугацаанд энэ чиглэлээр харьцангуй тогтмол ажиллаж байгаа. СБД-ийн шүүгч Ч.Тунгалаг цаашид мэргэших хэрэгтэй болов уу ?...",  
- *Энхбаяр*: эмгээгч  
"...емгээгч Э.Болорчулуун, Л.Шинэн нар, мэргэшсэн хуульч, эмгээгч, шүүгч нар маш цөөхөн...",  
- *Б.Ерэнтэй*: "Зууны мэдээ", сонины орлогч эрхлэгч  
"...Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч Ч.Тунгалаг гэж ганцхан шүүгчийг мэднэ. Шүүгч еерийн итгэл үнэмшлээр шийднэ гэсэн нэрийн дор мэтгэлцсэн талуудыг аль алинд нь тал засч "тугалыг турааж эхийг нь эцээхгүй" бөөрөнхий шийдвэр гаргадаг..." гэх зэргээр санал бодлоо илэрхийлжээ.

3.3.3 Харин доорх нэр бүхий судалгаанд хамрагдсан хүмүүс энэ талаар "мэдэхгүй" гэж хариулт өгчээ.

- *С.Баярмөнх* : "Сэрүүлэг" сонины эрхлэгч  
"...энэ салбараар дагнан мэргэшсэн хуульч мэдэхгүй...",  
- *Д.Заяабат* "Снедер" сонин албаны дарга  
"...одоогоор яг дагнасан хуульч, эмгээгч, шүүгч байхгүй...",  
- *Б.Нямсүрэн* СБДүүргийн шүүхийн шүүгч "...би энэ талаар сайн мэдэхгүй...",  
- *Б.Сарантуяа*: ЧДШүүхийн шүүгч  
"...хэвлэл мэдээллийн салбараар дагнан мэргэшсэн хуульчдийг нэрлэж мэдэхгүй, хэрэв мэргэшсэн нөхцөлд мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж байх шаардлагатай...",  
- *Л.Шинэн*: эмгээгч,  
"...мэдэхгүй..." гэх зэргээр хариулжээ.

3.4 Сэтгүүлчдэд зориулсан сургалт явуулах шаардлага бий юу ? гэдгийг

"Сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллага, ТББ-д Үндсэн хуулиар олгогдсон хууль зүйн баталгаа хэвлэл мэдээллийн хууль эрх зүйн болон сэтгүүлчдийн эрх үүрэг хариуцлага, сэтгүүлчид хэрэг маргаанд холбогдсон вед хууль зүйн туслалцаа хэрхэн авах болон хэрэг маргаанд холбогдох, шүүхэд дуудагдахаас яаж урьдчилан сэргийлэх, энэ талаар сургалт явуулах шаардлагатай эсэх" гэсэн асуултаар судлав.

3.4.1. Энэ асуултанд судалгаанд оролцсон 18 хүн буюу 100 хувь "энэ бол шаардлагатай зүйл" хариулжээ. Тухайлбал,

- *С.Баярмөнх* : "Сэрүүлэг" сонины эрхлэгч  
"Ийм сургалт явуулах нь шаардлагатай. Ялангуяа, сэтгүүлчид, сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга нарт. Учир нь шүүх хурал дээр хариуцагч хууль, эрх зүйн мэдлэггүйгээс ялагдах нь элбэг байдаг"  
- *Д.Заяабат*: "Снедер" сонины албаны дарга  
"Хууль эрх зүйн наад захын мэдлэг дутмагаас сэтгүүлчид шүүхэд дуудагдах нь элбэг. Үнэн зүйл бичсэн ч эсрэг тал нь шүүхэд өгдөг. Үүнийг няцаахын тулд баримт цуглуулахаас эхлээд хуулийн ялангуяа процессын наад захын мэдэгдэхүүнтэй байх шаардлагатай".



- Б.Сарантуяа: ЧДШvvхийн шvvгч

“Сургалт явуулснаар тэд дахин шvvхэд дуудагдах, хэрэг маргаанд оролцохдоо эрх зvйн мэдлэгтэй, соёлтой оролцох vндэслэлтэй”.

- Ханддолгор: “Yг” сонины эрхлэгч

“Сургалт явуулах нь шаардлагатай, гэхдээ нэг, хоёр удаа сургалт явуулснаар асуудал шийдэгдэхгvй”.

- Б.Ерэнтэй: “Зууны мэдээ” сонины орлогч эрхлэгч

“Хариуцлагатай сэтгvvл зvй гэж ярьж байгаа енее вед сургалт явуулж, манайд хамгийн их маргаан дэгдээдэг нэр тер гутаах, улсын нууцыг задалсан гэх хэргvvдэд ямар тохиолдолд ”унаж” болох, vvнээс хэрхэн зайлсхийж бичиж туурвих вэ гэдгийг нэн тvрvvнд ойлгуулах хэрэгтэй”.

- Ё.Энхбулган: емгеегч

“Сургалт явуулах шаардлагатай. Сэтгvvлчид, хэвлэл мэдээллийн байгууллагынхан еерсдийн эрхэлж буй вйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зvйн ерген мэдлэгтэй болбол бусдад эд херенгийн бус гэм хор хуруулахаас еерсдее ч эд херенгийн хохиролд орохоос урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой”.

Дерев. Хэвлэл мэдээллийн талаар хуульчдад зориулсан сургалт болон гарын авлагын шаардлага хэрэгцээ хэр байгааг судалсан тухай

4.1 Энэ асуудлыг емнех судалгаанд хамрагдсан 43 хvнээс анкетын асуултаар судлав.

4.2 Хуульчдад зориулсан сургалт шаардлагатай эсэхийг:

“Хуульч, хуулийн байгууллага болон хуулийн чиглэлээр вйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын дунд челеет хэвлэл, ардчилсан нийгэм дэхь хэвлэл мэдээллийн vvрэг, ач холбогдолын талаар сургалт явуулах хэрэгтэй эсэх” гэсэн асуултаар тодруулсан.

4.2.1 Энэ асуултыг дээрх хоёр судалгаанд хамрагдсан хvmvvсийн дунд тавьсан юм.

1/ 83.7 хувь буюу 36 хvн “шаардлагатай”

2/ 16.3 хувь буюу 7 хvн “шаардлагагvй” гэж vзжээ.

4.2.2 Асуултанд “шаардлагатай” гэж хариулсан хvmvvс дараахь байдлаар хариулжээ.

Yvнд:

- Б.Цогням: УДШvvхийн шvvгч

“Хуульчийн сэтгvvл зvйн боловсрол, мэдлэгийг дээшлvvлэх зорилгоор сургалт явуулах, мэргэшvvлэх, дагнах чиглэл баримтлах нь хэвлэл, мэдээллийн байгууллага, сэтгvvлчтэй холбогдох аливаа хэрэг, маргааныг vнэн зев, шудрага шийдвэрлэх ач холбогдолтой”.

- Ж.Амарсанаа: Yндсэн хуулийн цэцийн гишvvн

Тодорхой ойлголт егех нь зев, томоохон хэмжээнд энэ чиглэлийн хэрэг, маргаан шийдэхэд энэ талын мэдлэг, мэдээлэл чухал.

- Б.Ундрах: Нийслэлийн шvvхийн шvvгч

Шаардлагатай, хэвлэл мэдээллийн онцлогийг сайн мэдэх нь хэрэг шийдэхэд чухал нелеетэй.

- Р.Хадбаатар: Монголын Сонины холбоо

“Ойлгуулах vvднээс хэрэгтэй”.

- Б. Менхбал: Сансар КаТВ

“...хэрэгтэй байх, бид хуульчидтай хамтарч нэвтрvvлэг хийж байсан, тэгэхэд сэтгvvлчдийн талаар буруу ойлголттой байсан...”

- Ц.Дашдондов:

“...Хэвлэл мэдээлэлтэй холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэхэд хууль зvйн vvднээс нь хандахаас гадна хvний эрх, сэтгvvл зvйн салбарын vндсэн ойлголт, зарчим, мэдлэг

шаардлагатай. Иймд салбарын онцлогийг мэдэж байх нь зөв шийдвэр гаргахад нөлөөтэй...”

- Ж.Туяа: СБДШvvхийн шvvгч

“...Сургалт явуулахад илvvлдэхгvй. Яагаад, хуульч, ажилтануудын дээрх сэдвийн хvрээн дэх ойлголт харилцан адилгvй байж болох юм...”

- Б.Ерэнтэй: Зууны мэдээ сонины орлогч эрхлэгч

“Сургалт явуулах шаардлагатай, чөлөөт хэвлэлийн vүргээс гадна сэтгvvлчийн хөндсөн асуудлын ач холбогдолыг хэмжих, цэгнэх vнэлгээ ойлголтыг хуулийнханд суулгаж өгөхгvй бол хэлэлцэгч талуудыг маргааны вөд тэдэнд анхны мэдэгдэхvүн олгох гэж цаг vрсэн утгагvй ажил болдог”.

- С.Баярменх: “Сэрvvлэг” сонины эрхлэгч

“Сургалт явуулах нь хэрэгтэй, учир нь хууль, хуулийн байгууллагын ажилтнууд сэтгvvл зvйн талаар нарийн ойлголт байдаггvй, зарим нь чөлөөт хэвлэлийг шар хэвлэл гэж vздэгээс асуудлын мөн чанарыг авч vзэлгvй шууд л яллах талаас нь ханддаг”.

4.2.3 Харин шаардлагагvй гэж vзсэн хvмvvс дараахь байдлаар тайлбар хийжээ. Тухайлбал,

- Б.Нямсvрэн: СБДШvvхийн шvvгч

“...Энэ талаар сургалт явуулах шаардлаггvй байх...”

- Б.Сарантуяа: СБДШvvхийн шvvгч

“...одоогийн нөхцөлд хэвлэл мэдээллийн ач холбогдол, vүргийг сэтгvvлч болгон өндөр ухамсарлаж ойлгож байгаа учраас сургалт явуулах шаардлагагvй байх...”

Л.Болормаа “Снедер” сонин, Д.Цэрэнжав “Монголын ОНМХ-ийн тойм” нар “мэдэхгvй” гэж тус тус хариулжээ.

4.3. Гарын авлага бий эсэхийг “Танд байнга ашигладаг хэвлэл мэдээлэлтэй холбоотой хууль тогтоомжийн эмхтгэл эсхvл сурах бичиг, гарын авлага бий юу ? Цаашид бий болгох шаардлагатай юу ?” гэсэн асуултаар судлав.

4.3.1. Энэхvн асуултанд судалгаанд оролцсон хvмvvсийн

1. 64.9 хувь нь “байхгvй” гэсэн бол,

2. 35.1 хувь “гарын авлага бий” гэж хариулжээ.

Тухайлбал, гарын авлага бий гэж хариулсан хvмvvс дараахь байдлаар тайлбар хийжээ.

- Б.Нямсvрэн СБДШvvхийн шvvгч

“...байгаа, миний хувьд хангалттай...”

- Б.Сарантуяа СБДШvvхийн шvvгч

“...дээд шатны шvvхээс гаргасан гарын авлагын хэмжээнд байдаг.”

- Ж.Амарсанаа Үндсэн хуулийн цэцийн гишvvн

“...хангалттай бий, цаашид хэрэгцээ, цаг хугацаагаа дагаад л бий болно шvv дээ...”

- М.Мөнх-Мандах Монголын Хэвлэлийн Хvрээлэн

“... Глоб интернейшнл”-ийн ном, Т.Баасансvрэнгийн ном...”

- Р.Хадбаатар Монголын Сонины Холбоо

“...байгаа, Ш.Үнэнтөгс, “Глоб интернейшнл”-ийн ном бий...”

- Б.Ерэнтэй “Зууны мэдээ” сонины орлогч эрхлэгч

“...Ж.Туулын эмхтгэсэн 2001 оны Хэвлэл мэдээлэлтэй холбогдолтой Монгол улсын хууль” /Глоб интернейшнл ТББ/